

ДУНДГОВЬ АЙМГИЙН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

2023 оны 1 дүгээр сарын 16

Мандалговь хот

НЭГ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО


Аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, хүрсэн түвшнийг тусгагдсан зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй харьцуулан үр дүнг үнэлж удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан аргачлалын дагуу хийж үнэлгээний дүнг гаргасан.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөг нийт 5 бүлгийн хүрээнд 69 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн батлуулсан.



АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо		69
Үр дүнтэй	100	51
Тодорхой үр дүнд хүрсэн	90	-
	70	1
Эрчимжүүлэх шаардлагатай	50	-
	30	-
Үр дүнгүй	0	10
(хүрсэн түвшин-суурь түвшин)/(суурь түвшин зорилтот түвшин)	100-90	2
	90-70	4
	70-50	1
Хэрэгжилтийн хувь		83.46

ТАЙЛАНГИЙН ХУГАЦААНД ДАРААХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА.

Халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэгт **36070** хүн хамрагдахаас **22252** иргэнийг буюу **61.7** хувь, урьдчилан сэргийлэх үзлэгт нийт **24782** иргэнийг хамруулж үзлэгт хамрагдалт **34.2** хувьтай байна.



“Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах” ажлын хүрээнд 2022 онд эмнэлгийн тусламж үйлчилгээнд 55 төрлийн нийт 830,3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг улсын төсөв, орон нутгийн төсвөөр шийдвэрлэв. Тоног төхөөрөмжийн хангалт 90,6 хувьд хүрсэн.



Сайнцагаан сумын харьяа эрүүл мэндийн салбарынханд ОНХС-ийн хөрөнгөөр 105.8 сая төгрөгийн шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг хүлээлгэн өглөө.



Аймгийн Нэгдсэн эмнэлэгт байгуулж **1,152,2** тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжөөр ханган **347,8** сая төгрөгийн засвар үйлчилгээ хийж ашиглалтад орууллаа.



Ахмадын өргөө, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төв 100 хувийн гүйцэтгэлтэй байна.



Цэнгэлдэх хүрээлэнгийн ажлын гүйцэтгэгчээр “Зуут Констракшн” ХХК 2.450 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж, 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлсэн. Тус хүрээлэнгийн спортын талбайд үндэсний сурын 10 зурхайтай шинэ талбай, шагайн харвааны 8 багийн тоглолтын талбай зэргийг ашиглалтад орууллаа.



Гурвансайхан сумын Их газрын чулуу, Өлзийт сумын Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт газар тус тус “Отоглох цэг” байгуулж тохижилтын ажлыг хийсэн.





Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтын 40 сая төгрөгийн санхүүжилтээр Төв халхын дуулалт жүжгийн театрын барилгын гадна пасадны засвар, Сайхан-овоо сумын Соёлын төвийн барилгын их засварын ажлын гүйцэтгэл 100 хувьтай хийгдсэн.



“Цахим төр-Ухаалаг Дундговь” цогц системийг нэвтрүүлэх ажлыг 80 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, системийг хөгжүүлж, төрийн байгууллагуудын мэдээ, тайлангийн үйл ажиллагааг 100 хувь цахимжуулах нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан аймгийн цахим хуудсыг шинэчлэн, 15 сумыг цахим хуудастай болгосон. Аймгийн хэмжээнд аймаг сумдын шаардлагатай албан хаагчдад албан тушаалын тоон гарын үсэг олох ажлын зохион байгуулж 15 сумын 58 албан хаагчдад тоон гарын үсгийг олгоод байна. Төрийн байгууллагуудын албан цахим хаягийг Zimbra систем рүү шилжүүлж, мэйл админ удирдлагыг

сумдад үүсгэж, аймгийн болон бүх сумдын 1800 төрийн албан хаагчийг албан цахим хаягтай болгож, албан харилцаанд 100 хувь ашиглаж байна.



Хулд сумын Эрэн хайх аврах бүлэг байгуулан Бүгд Найрамдах Турк улсын Онцгой байдлын албанаас ирүүлсэн тусламжийн хөрөнгөнөөс тус аврах бүлэгт 11 ширхэг 66,536,000 төгрөгийн аврах ажиллагааны багажийг худалдан авсан. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газраас орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 35.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг олгосноор техник, багаж хэрэгслийн хангалт 75 хувьтай болсон байна.



“Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд 2022 онд орон нутагт нэн шаардлагатай боловсон хүчин бэлтгэх, зорилтын хүрээнд орон нутгийн боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн, соёлын салбарт шаардлагатай төгсөх курсийн 22 оюутантай гэрээ байгуулан 57.3 тэтгэлэгт хамрууллаа.



Төрийн албан хаагчийн ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, нийгмийн асуудал, сургалтын төлбөрийн дэмжлэг зэрэгт нийт 190 төрийн албан хаагчид 201,1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна.



“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Дундговיו ногооруулъя” хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд 122,884 мод, сөөг тарьж ургууллаа. “Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх” хөтөлбөрийн хүрээнд 8 га, ойн зурвас байгуулах ажлын хүрээнд 5 га нийт 13 га газарт ойн зурвас байгуулж нийт ногоон байгууламжийн хэмжээ 382.4 га болсон.



2022 оны улсын төсвийн 2,883,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мандалговь - Улаанбаатар, Мандалговь- Даланзадгад чиглэлийн Улсын чанартай хатуу хучилттай авто замын арчилгаа, засварын ажил хийгдсэн байна.



Сайнцагаан суманд нийтийн орон сууцны зориулалттай 6 барилга шинээр баригдаж 145 өрх орон сууцаар хангагдах боломж бүрдлээ.



Азийн хөгжлийн банкны хөрөнгө 9,1 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвд хоногт 3000 м³ хүчин чадалтай биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж, гэр хорооллын 5,57 км гадна бохир усны сүлжээний ажлыг хүлээн авлаа.



Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх, эвдэрсэн газрыг бууруулах зорилгоор “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний хүрээнд 11 сумын нутаг дэвсгэрийн 9 талбар бүхий газарт 15,5 талбайд техникийн нөхөн сэргээлт хийж биологийн нөхөн сэргээлтийг 24.74 га-д хүргэж нийт нөхөн сэргээгдсэн талбайн хэмжээг 145,76 га-д хүрсэн.



Баянжаргалан, Өндөршил, Луус сумдын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, магадлалаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн.



Аймгийн төвд зөвшөөрөлгүй газар ашиглаж байгаа иргэдийн газар чөлөөлөх ажлын хүрээнд нийт 67 байршилд газар чөлөөлөх мэдэгдэх хуудас хүргүүлж үүний 67 байршлын газрыг чөлөөлсөн.



ДУТАГДАЛТАЙ БОЛОН ХЭРЭГЖЭЭГҮЙ АРГА ХЭМЖЭЭ

	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Шалтгаан
1	Говь-Угтаал сумын Спорт заалны барилгын ажлыг дуусгаж ашиглалтад оруулах	"Бум констракшн" ХХК-тай 850,21 сая төгрөгийн гэрээ байгуулан Газар шороо, карказ, гадна ханын өрлөгийн ажил хийгдэж байна. Ажлын явцын хувь 45%-тай үргэлжилж байна. 2022 онд ямар нэг ажил хийгдээгүй болно.	Төсөв улсын төсөвт суусан боловч Гүйцэтгэгч байгууллага ямар ч ажил хийгээгүй.
2	Сайнцагаан, Эрдэнэдалай, Дэлгэрцогт суманд шинээр цэцэрлэгийн барилга барих	Эрдэнэдалай сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Сод ээл" ХХК шалгарч 2.0 тэрбум төгрөгийн гэрээ байгуулагдаж, техникийн нөхцөлийн ажил хийгдсэн. Сайнцагаан сумын 2-р цэцэрлэгийн барилгын ажлын Гүйцэтгэгчээр "Энх Баялаг Констракшн" ХХК шалгарч 2.7 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан буулгалтын ажил хийгдсэн. Дэлгэрцогт сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгчээр "Ашид бюльдинг" ХХК шалгарч 2.4 тэрбум төгрөгийн гэрээ байгуулаад байна.	Дээрх 3 цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгч 2022 оны 7-11 сард шалгарч гэрээ хийгдсэн мөн тухайн оны санхүүжилт нь зөвхөн буулгах зардал туссан зэргээс шалтгаалсан.
3	Говь-Угтаал суманд шинээр дотуур байрын барилга барих	Барилгын гүйцэтгэгчээр "Есүй-Ордон" ХХК шалгарч 1.6 тэрбум төгрөгийн гэрээ байгуулаад байна. Он дамжин хэрэгжинэ.	Гүйцэтгэгчтэй 2022 оны 11 сард гэрээ байгуулсан учир ажил эхлээгүй.
4	Төв Халхын Дуулалт Жүжгийн Театрын шинэ барилга барьж, ашиглалтад оруулах	Соёлын сайд Ч.Номиныг аймагт ажиллах үеэр барилгын ажлын нөхцөл байдлыг газар дээр нь танилцуулж, уг ажлыг үргэлжлүүлэн барьж, ашиглалтад оруулах хүсэлтийг тавьсан.	Шүүхийн маргаантай байгаа тул ямар нэг ажил хийгдээгүй.
5	Дэлгэрхангай сумдын соёлын төвийн барилга шинээр барих	Төрийн хэмнэлийн тухай хуулийн дагуу хасагдсан. (хуулийн 7.1, 13.1.6)	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хасагдсан. (хуулийн 7.1, 13.1.6)
6	Дэрэн суман дахь	Дэрэн сумын тэжээлийн үйлдвэр	тоног төхөөрөмж, ажиллах

	тэжээлийн үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглаж аймгийн тэжээлийн нөөцийн 60-аас доошгүй хувийг үйлдвэрлэх	тоног төхөөрөмж, ажиллах хүч, санхүүгийн эх үүсвэргүй улмаас тэжээл үйлдвэрлэх боломжгүй байсан.	хүч, санхүүгийн эх үүсвэргүй улмаас тэжээл үйлдвэрлэх боломжгүй байсан.
7	Түр хамгаалах байр байгуулах	Хөрөнгө санхүүгийн асуудлаас тасарсан. 2023 оны төсөвт 250,0 төгрөг тусган хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	Санхүүжилт шийдэгдээгүй. 2023 оны төсөвт санхүүжилтийн асуудлыг тусгасан.
8	Төрийн өндөрлөгийн чиглэлийн хамгаалалтад туулах чадвар сайтай автомашинаар хангах		Хөрөнгийн асуудлаас болж тасарсан.
9	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байранд телекамер бүхий димапон систем нэвтрүүлэх.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байранд телекамер бүхий димапон систем нэвтрүүлэх ажлыг орон нутгийн төсвөөс батлан тендер шалгаруулалт зарласан ба Төсвийн хэмнэлтийн тухай хууль гарсантай холбогдуулан тус тендер задрах хугацаандаа тодотголд орж төсвийг буцаан татсан.	Санхүүжилт шийдэгдээгүй.
10	Эрдэнэдалай сумын 2 км хатуу хучилттай авто зам, гэрэлтүүлгийг ашиглалтад оруулах	2022 онд ажил хийгдээгүй.	Хөрөнгийн асуудлаас болж тасарсан.

Хөрөнгө санхүүгийн зарцуулалтын мэдээ

№	Бүлэг	Эх үүсвэр	Зарцуулалт / сая төгрөг/	Дүн /сая төгрөг/
1	Хүний хөгжлийн бодлого	УТХО	22,771.3	26,371.5
		ОНХО	900.2	
		Хандив, тусламж	2,700.0	
2	Эдийн засгийн бодлого	УТХО	5,423.2	6,995.2
		Төсөл хөтөлбөр	1,572.0	
3	Засаглалын бодлого	УТХО	-	377.7
		ОНХО	377.7	
4	Ногоон хөгжлийн бодлого	ОНХО	122.0	122.0
5	Орон нутгийн тогтвортой хөгжлийн бодлого	УТХО	1,450.0	2,507.0
		ОНХО	1,057.0	
Нийт дүн				36,373.4

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөг 5 бүлгийн хүрээнд 69 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан явцын тайланг 2022 оны 11 сарын 30-ны байдлаар гарган хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 12 дугаар хуралдаанд танилцуулан хурлаас “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээг өгч хурлын 58 дугаар тогтоолоор баталгаажуулсан.

Аймгийн хөгжлийн жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөрөнгө оруулалт, хандив тусламж,

төсөл хөтөлбөрийн 36.373.4 төгрөгийн санхүүжилтээр бүтээн байгуулалт болон хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад нийт 69 арга хэмжээнээс 10 арга хэмжээ үр дүнгүй хэрэгжсэн байна. Энэ нь санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй, 2022 оны төсөвт тусгагдаагүй зэрэг хөрөнгө санхүүгийн шалтгаантай байгаа нь төрийн хэмнэлтийн тухай хуультай шууд холбоотой гэж үзэж болохоор байна.

Аймгийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 71.9 хувьтай үнэлж 3 заалт бүхий зөвлөмж өгсөн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сум, агентлагийн удирдлагууд, төрийн албан хаагчдад бодлогын баримт бичиг боловсруулах, тайлагнах арга зүйн сургалтыг зохион байгуулж хэрэгжүүлэх арга хэмжээг суурь түвшин, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлж шалгуур үзүүлэлтийн дагуу тайлан бичиж, үнэлж дүгнэсэн.

Үүний үр дүнд 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг иргэдийн саналд үндэслэн төлөвлөлтийн шаардлага, зарчимд нийцүүлэн боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

2022 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 83.46 хувийн хэрэгжилттэй буюу **“Тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэлж үнэлгээний тайланг хүргүүлж байна.

ТАВ.ЗӨВЛӨМЖ

Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын хуулийн 18.5 –д **“Хөгжлийн асуудал хариуцсан аймаг, нийслэлийн байгууллагууд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд суурилсан Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг 9 дүгээр сарын 01-ний дотор боловсруулна”** гэж заасны дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн төлөвлөлтийн шаардлагыг ханган томьёолж, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлон, суурь түвшин, хүрэх түвшнийг бодитой тооцон төлөвлөж Эдийн засаг, хөгжлийн яамаар хянуулан хуульд заасан хугацаанд батлуулах

Жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт удаашралтай болон тасарч болзошгүй заалтуудыг хяналтад авч, эрчимжүүлэх арга хэмжээ зохион байгуулан хэрэгжилт, үр дүнгийн талаар удирдлагуудыг мэдээллээр хангаж байх

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС